


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/61

Улаанбаатар хот

Г Г

2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг
дэмжих жил” болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 4.2.2, 8.1.21, 13.1.1, 13.2, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласугай.
2. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд орон нутаг, байгууллагын онцлогт тохирсон төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тайланг 2017 оны 06, 12 дугаар сарын 5-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт даалгасугай.
4. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, ажлын явц, үр дүнг аймаг, нийслэл, байгууллага тус бүрээр хагас, бүтэн жилээр гарган яамны Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



**“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН
ХУРЭЭНД ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/Д	Хэрэгжүүлэх Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх Нэгж	Хугацаа, улирлаар				Шалгуур үзүүлэлт
			I	II	III	IV	
1	“2017-Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” хэвлэлийн бага хурал зохион байгуулах	НЭМГ	x				Үйл ажиллагааны тайлан
2	Эрүүл мэндийг дэмжих сангийн журам болсовсруулан батлуулах, үйл ажиллагааг эхлүүлэх	НЭМГ	x	x	x	x	Журам, тайлан
3	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг шалгаруулах журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх	НЭМГ, НЭМҮТ	x	x	x	x	Журам, тайлан
4	“Эрүүл мэндийн удирдах ажилтны улсын зөвлөгөөн -2017” хурээнд “Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал” хэлэлцүүлгээ зохион байгуулах	ТЗҮГ БТГ НЭМГ	x				Хэлэлцүүлгийн зөвлөмж, шийдвэр
5	УИХ-ын гишүүдтэй “Зангиагүй уулзалт” зохион байгуулах	Газар, хэлтсүүд	x	x	x		Уулзалтуудын танилцуулга.
6	Зорилтот булийн хүн амын дунд вирусийн хепатит В, С халдварын эрт илрүүлгийг че шаттайгаар зохион байгуулах	ЭТГ	x	x	x	x	Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 02-дэхүүн
№/дугаар тушаалтын хавсралт



7	Сурьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийг өвчлөл өндөртэй 4 аймагт зохион байгуулах	НЭМГ		x	x	Үзлэгт хамрагдсан хүний тоо
8	“Эрүүл мэндэд нелеөөлөх сөрөг хүчин зүйлийн эрсдэлийг бууруулахад бусад салбарын оролцоо” цувлал уулзалт, хэлэлцүүлэг	БТГ НЭМГ		x		Уулзалт, хэлэлцүүлгийн тайлан
9	Архангай, Хөвсгөл аймгуудад Шурхай улирдлагын нэгж байгуулах	НЭМГ		x	x	ШУН байгуулагдсан байна.
10	Иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадллыг сайжруулах зорилгоор аян зохион байгуулах. /Сурьеэ, Осол гэмтэл, тулэгдэл, Томуу, Томуу төст өвчин, агаарын бохирдол, Хавдар, Сэтгэцийн эрүүл мэнд, Эрүүл орчин, ДОХ/БЗДХ, Гэр бүл төлөвлөлт, Оюутны эрүүл мэнд, Амны хөндийн эрүүл мэнд, Эрүүл, зөв хооллолт, Эрүүл ажлын байр гэх мэт/	НЭМГ	x	x	x	Аян зохион байгуулсан тайлан.
11	Аймаг, дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах	НЭМГ, НЭМҮТ	x	x	x	Үйл ажиллагааны тайлан
12	“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн үйл ажиллагааг дүгнэх	НЭМГ			x	Үйл ажиллагааны тайлан